



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар В/392

Улаанбаатар хот

**Багануур дүүргийн "Багануур тохижилт"
ОНӨААТҮГ-ын данс бүртгэлээс тээврийн
хэрэгсэл хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйл, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Техникийн комиссын дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болсон, засаж сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тогтоогдож, сэлбэгийн буюу хоёрдогч түүхий эдийн зориулалтаар татан төвлөрүүлж худалдахаар шийдвэрлэгдсэн 25,000,000.0 /хорин таван сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Тоёота приус-30 маркийн 01-15 БРА улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Багануур дүүргийн "Багануур тохижилт" ОНӨААТҮГ /Д.Батнасан/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй тээврийн хэрэгслийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийх, тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарыг хураан авч авто тээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс хасуулахыг Багануур дүүргийн "Багануур тохижилт" ОНӨААТҮГ /Д.Батнасан/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга Д.Төмөрбаатарт тус тус даалгасугай.

~~ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ~~

Ш.ҮНЭНБАТ



115050000879